



# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/11/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЧАНДМАНЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2023  
ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор: Б.Адъяасүрэн

Утас: 70273204 Цахим хаяг: [adiyasurenb@audit.gov.mn](mailto:adiyasurenb@audit.gov.mn)



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

## АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	9
3.4.1 Мөнгөн хөрөнгө .....	11
3.5.2 Авлага .....	11
3.5.4 Бараа материал .....	12
3.5.6 Үндсэн хөрөнгө .....	12
3.5.7 Өр төлбөр .....	13
3.5.10 Засгийн газрын хувь оролцоо.....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
4.5.1 Завсрын аудитын талаар .....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	19
5.3 Зөвлөмж.....	19
7. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	21

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.25 № 4/239  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г ТӨВ АЙМГИЙН БАЯНЧАНДМАНЬ  
СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Г.АРИУНБОЛД ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Төв аймгийн Баянчандмань сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 18-ны 01 дүгээр тогтоолоор сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн 49 зорилт 209 арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 95.5%-тай буюу “Үр дүнтэй” гэж дүгнэсэн байна.

**Аудитын гол асуудал**

Тухайн байгууллагын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг дарга тайлант онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 282,295.6 мянган төгрөгийн зам засвар, цэцэрлэгийн гадна талбайн тохижилт, 3 дугаар хорооны хүүхдийн тоглоомын талбайн засварын ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Мөн орон нутгийн төсвийн шилжих үлдэгдлээр Цагдаагийн хэсэг, Соёлын төв, Одод цэцэрлэгийн засвар, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг 186,300.0 мянган төгрөгөөр тус тус санхүүжүүлсэн байна.

## Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,070,732.0	1,551,741.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	457,272.2	912,466.6
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	454,964.5	474,889.4
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	158,495.2	164,385.6
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,544,267.4	2,378,653.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	1,544,267.4	2,378,653.0
39200	Биет хөрөнгө		1,410,984.8	2,245,642.0
39300	Биет бус хөрөнгө	13	133,282.7	133,011.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		2,614,999.4	3,930,394.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		9,848.5	5,378.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	9,848.5	5,378.1
41300	Өглөг	17а, 17б	9,848.5	5,378.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		2,605,150.9	3,925,016.5
51	Засгийн газрын хувь оролцоо		2,605,150.9	3,925,016.5
51200	Хуримтлагдсан үр дүн		1,491,030.4	2,847,601.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		2,614,999.4	3,930,394.6

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,246,149.2	3,631,479.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	932,108.4	1,692,580.2
110	Орлогын албан татвар	586,289.2	1,168,517.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	614,248.1	1,197,517.4
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-27,958.9	-29,000.0
113	Хөрөнгийн албан татвар	113,390.0	116,127.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж	232,429.2	407,935.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	738,145.3	1,489,196.2
120	Нийтлэг татварын бус орлого	738,145.3	1,489,196.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,575,895.5	449,703.3
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,841,479.9	1,759,238.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,632,097.6	1,663,239.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,294,616.6	1,589,183.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	300,930.2	491,427.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,742.0	60,778.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	326,502.2	57,386.2
2104	Хангамж, бараа материалын зардал	101,116.2	65,026.7
2105	Нормативт зардал	68,488.2	65,695.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	55,711.5	12,101.7
2107	Томилолт, зочны зардал	7,926.6	5,646.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	51,371.0	49,518.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	344,828.6	781,603.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,337,481.0	74,056.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	209,382.3	95,999.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	404,669.3	1,872,241.1
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,887,892.8	551,337.6
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-4,483,223.4	1,320,903.5

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,012,232.5	2,682,811.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	932,108.4	1,692,580.2
110	Орлогын албан татвар	586,289.2	1,168,517.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	614,248.1	1,197,517.4
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-27,958.9	-29,000.0
113	Хөрөнгийн албан татвар	113,390.0	116,127.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж	232,429.2	407,935.4
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	25,161.8	90,007.8
1181	Газрын төлбөр	195,175.0	313,212.0
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	12,092.4	4,715.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	504,228.5	540,527.6
120	Нийтлэг татварын бус орлого	504,228.5	540,527.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,575,895.5	449,703.3
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,403,211.7	1,345,525.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,403,211.7	1,345,525.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,063,127.4	1,271,469.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	300,930.2	491,386.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,742.0	60,778.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	326,802.2	91,455.6
2104	Хангамж, бараа материалын зардал	65,986.7	65,019.4
2105	Нормативт зардал	74,874.7	77,587.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	56,611.5	13,251.7
2107	Томилолт, зочны зардал	7,926.6	5,646.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	51,340.2	47,054.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	140,913.2	419,289.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,340,084.3	74,056.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	609,020.8	1,337,285.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	217,724.7	773,652.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	217,724.7	773,652.2
2200	Дотоод эх үүсвэрээр	217,724.7	773,652.2
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-217,724.7	-773,652.2
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-234,678.8	-108,439.3
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	234,678.8	108,439.3
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	156,617.3	455,194.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	300,655.0	457,272.2
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	457,272.2	912,466.6

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,173,804.70	7,173,804.70
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-85,417.00	-85,417.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,088,387.70	7,088,387.70
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-13.3	-13.3
9	Тайлант үеийн үр дүн	-4,483,223.40	-4,483,223.40
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,605,150.90	2,605,150.90
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,605,150.90	2,605,150.90
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	35,667.00	35,667.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,640,818.00	2,640,818.00
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-36,705.00	-36,705.00
19	Тайлант үеийн үр дүн	1,320,903.50	1,320,903.50
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,925,016.50	3,925,016.50

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,239,011.7</b>	<b>1,984,216.6</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,184,846.8</b>	<b>1,129,854.1</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,181,346.8</b>	<b>1,126,354.1</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>455,163.1</b>	<b>444,634.7</b>
<b>210101</b>	Үндсэн цалин	258,982.7	275,116.7
<b>210102</b>	Нэмэгдэл	128,769.4	121,970.5
<b>210104</b>	Урамшуулал	60,811.0	47,455.6
<b>210105</b>	Гэрээт ажлын хөлс	6,600.0	91.9
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>56,895.2</b>	<b>55,096.2</b>
<b>210201</b>	Тэтгэврийн даатгал	38,688.8	38,124.4
<b>210202</b>	Тэтгэмжийн даатгал	4,551.7	4,485.4
<b>210203</b>	ҮОМШӨ-ний даатгал	3,641.2	3,588.2
<b>210204</b>	Ажилгүйдлийн даатгал	910.3	808.9
<b>210205</b>	Эрүүл мэндийн даатгал	9,103.2	8,089.4
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>468,983.0</b>	<b>438,872.8</b>
<b>210301</b>	Гэрэл, цахилгаан	65,471.5	56,216.7
<b>210302</b>	Түлш, халаалт	396,525.5	380,835.1
<b>210303</b>	Цэвэр, бохир ус	6,986.0	1,821.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>65,247.0</b>	<b>64,926.4</b>
<b>210401</b>	Бичиг хэрэг	5,750.0	5,750.0
<b>210402</b>	Тээвэр, шатахуун	31,235.5	31,235.5
<b>210403</b>	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,480.0	8,159.4
<b>210405</b>	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	15,500.0	15,500.0
<b>210406</b>	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,281.5	4,281.5
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>17,251.7</b>	<b>17,236.7</b>
<b>210604</b>	Урсгал засвар	17,251.7	17,236.7
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,646.6</b>	<b>5,646.6</b>
<b>210702</b>	Дотоод албан томилолт	5,646.6	5,646.6
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>53,273.0</b>	<b>47,054.2</b>
<b>210801</b>	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	50,153.5	44,007.5
<b>210802</b>	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	928.0	928.0
<b>210803</b>	Даатгалын үйлчилгээ	311.1	307.4
<b>210804</b>	Тээврийн хэрэгслийн татвар	1,200.0	1,178.9
<b>210805</b>	Тээврийн хэрэгслийн оношлогоо	165.0	117.0
<b>210807</b>	Газрын төлбөр	515.4	515.4
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>58,887.2</b>	<b>52,886.5</b>
<b>210901</b>	Бараа үйлчилгээний бусад зардал	58,887.2	52,886.5
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,500.0</b>	<b>3,500.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,500.0</b>	<b>3,500.0</b>
<b>213209</b>	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,500.0	3,500.0
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>814,164.9</b>	<b>745,923.2</b>
<b>221001</b>	Их засвар	445,491.6	417,158.4
<b>222001</b>	Тоног төхөөрөмж	344,204.6	328,764.8
<b>223001</b>	Бусад хөрөнгө	24,468.7	0.0
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>240,000.0</b>	<b>108,439.3</b>
<b>230001</b>	Эргэж төлөгдөх зээл	240,000.0	108,439.3
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,239,011.7</b>	<b>1,873,130.4</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>379,974.9</b>	<b>370,462.6</b>
<b>310004</b>	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	379,974.9	370,462.6
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,254,040.4</b>	<b>1,391,995.9</b>
<b>320001</b>	Орон нутгийн төсвөөс	1,254,040.4	1,391,995.9
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>604,996.4</b>	<b>110,672.0</b>
<b>350001</b>	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	240,000.0	110,672.0
<b>350003</b>	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	364,996.4	0.0
<b>4</b>	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	194,400.3
<b>5</b>	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	83,314.2
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>56</b>	<b>56</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>2</b>	<b>2</b>
<b>610001</b>	Төсвийн байгууллага	2	2
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>27</b>	<b>27</b>
<b>620001</b>	Удирдах ажилтан	8	8
<b>620002</b>	Гүйцэтгэх ажилтан	10	10
<b>620003</b>	Үйлчлэх ажилтан	4	4
<b>620004</b>	Гэрээт ажилтан	5	5

<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>27</b>	<b>27</b>
<b>650001</b>	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11	11
<b>650009</b>	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10	10
<b>650011</b>	Улс төрийн албан хаагч (УТ)	6	6

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**  
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>71,899.72</b>	<b>91,281.58</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>71,899.72</b>	<b>91,281.58</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>54,670.78</b>	<b>87,825.65</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>0.00</b>	<b>46,751.95</b>
<b>210101</b>	Үндсэн цалин	0.00	10,551.35
<b>210102</b>	Нэмэгдэл	0.00	36,200.60
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>0.00</b>	<b>5,682.39</b>
<b>210201</b>	Тэтгэврийн даатгал	0.00	3,968.49
<b>210202</b>	Тэтгэмжийн даатгал	0.00	462.73
<b>210203</b>	ҮОМШӨ-ний даатгал	0.00	575.50
<b>210204</b>	Ажилгүйдлийн даатгал	0.00	80.09
<b>210205</b>	Эрүүл мэндийн даатгал	0.00	595.58
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,388.80</b>	<b>93.00</b>
<b>210402</b>	Тээвэр, шатахуун	2,388.80	93.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>400.00</b>	<b>0.00</b>
<b>210801</b>	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	400.00	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>51,881.98</b>	<b>35,298.31</b>
<b>210901</b>	Бараа үйлчилгээний бусад зардал	51,881.98	35,298.31
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>17,228.94</b>	<b>3,455.93</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>5,119.20</b>	<b>0.00</b>
<b>213209</b>	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,119.20	0.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>12,109.74</b>	<b>3,455.93</b>
<b>213305</b>	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	12,109.74	0.00
<b>213403</b>	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	3,276.26
<b>213405</b>	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	179.67
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>71,899.72</b>	<b>91,281.58</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>71,899.72</b>	<b>91,281.58</b>
<b>131104</b>	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,124.09	75,090.67
<b>131105</b>	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	49,775.63	16,190.91

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг дарга нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д “Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, түүнчлэн тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн” гэж заасан ба мөн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д “Сумын Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 59.1.1-59.1.23-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлдэг байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 14.2.1-14.2.12-т заасан бүрэн эрхийг, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан бүрэн эрхийг тус тус хэрэгжүүлэн, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаа аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид нэгтгэн тайлагнадаг байна.

Нийгмийн хариуцлагын хүрээнд Агроник ХХК төрөл бүрийн модны суулгац 2,995.0 мянган төгрөг, Иргэн Норовбанзад 3 ширхэг асар майхан 10,000.0 мянган төгрөг, Иргэн Гантөгс Төв аймгийн 100 жилийн ойн тоглолтод оролцогчдын зардал 3,000.0 мянган төгрөг, Иргэн Отгонсод Мазда3 DM суудлын автомашин 18,000.0 мянган төгрөг, Монвольфром ХХК сумын айл өрхийн 250 ширхэг гэрэлтүүлгийг 97,000.0 мянган төгрөг, Мон-Эгг ХХК Эрүүл мэндийн төвийн хуучин барилгын засвар 220,000.0 мянган төгрөгөөр, нийт 350,995.0 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг хийж гүйцэтгэсэн байна.

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг дарга тайлант онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 282,295.6 мянган төгрөгийн зам засвар, цэцэрлэгийн гадна талбайн тохижилт, 3 дугаар хорооны хүүхдийн тоглоомын талбайн засварын ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Мөн орон нутгийн төсвийн шилжих үлдэгдлээр Цагдаагийн хэсэг, Соёлын төв, Одод цэцэрлэгийн засвар, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг 186,300.0 мянган төгрөгөөр тус тус санхүүжүүлсэн байна.

Төв аймгийн Баянчандмань сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 18-ны 01 дүгээр тогтоолоор сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн 49 зорилт 209 арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 95.5%-тай буюу “Үр дүнтэй” гэж дүгнэсэн байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Баянчандмань сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Шилэн дансны тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамрагдаагүй, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Сумын Засаг даргын 2022 оны 5 дугаар сарын 30-ны А/212 захирамжаар томилогдсон сумын дотоод хяналтын баг нь 2023 онд 6 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Баталсан удирдамж төлөвлөгөөний дагуу нийгмийн салбар байгууллагууд, аж ахуй нэгж, худалдаа үйлчилгээний цэг, хоолны газруудын үйл ажиллагаанд удирдамжийн дагуу хяналт шалгалтыг хийж, ажлын дүгнэлт тайланг бичсэн байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын нэгтгэсэн тайланд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Аймгийн Засаг даргын захирамжаар 2021 оны 03 сард баталсан байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 3,930,394.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,315,395.2 мянган төгрөгөөр буюу 50.3 хувиар нэмэгдсэн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	457,272.2	912,466.6	455,194.4
<b>АВЛАГА</b>	454,964.5	474,889.4	19,924.9
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	158,495.2	164,385.6	5,890.4
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,544,267.4	2,378,653.0	834,385.6
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	2,614,999.4	3,930,394.6	1,315,395.2
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	9,848.5	5,378.1	-4,470.4
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,605,150.9	3,925,016.5	1,319,865.6
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,491,030.4	2,847,601.0	1,356,570.6
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	2,614,999.4	3,930,394.6	1,315,395.2

Эх сурвалж: Баянчандмань Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 912,466.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 455,194.4 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь орон нутгийн ерөнхий орлогын данс 824,608.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 571,069.7 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Авлагын эцсийн үлдэгдэл 474,889.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 19,924.9 мянган төгрөгөөр өссөн нь ЗДТГ-ын авлага 14,100.4 мянган төгрөг болж өмнөх оноос 13,384.0 мянган төгрөгөөр өссөн, Хоршоо хөгжүүлэх сангийн авлага 421,483.3 мянган төгрөг болж 7,205.1 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Бараа материалын эцсийн үлдэгдэл 164,385.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 5,890.4 мянган төгрөгөөр өссөн нь эмийн эргэлтийн сангийн бараа материал 70,320.2 мянган төгрөг болж 4,244.0 мянган төгрөгөөр өссөн, ИТХ-ын бараа материал 2,772.2 мянган төгрөг болж 2,001.9 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 2,378,653.0 мянган төгрөг болж, өмнөх оноос - 834,385.6 мянган төгрөгөөр өссөн нь ЗДТГ-ын үндсэн хөрөнгө 3,920,258.6 мянган төгрөг болж 938,893.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 5,378.1 мянган төгрөг болж 4,470.4 мянган төгрөгөөр буурсан нь эмийн эргэлтийн сангийн 7,633.4 мянган төгрөгийн өглөг төлөгдсөнтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 3,925,016.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,319,865.6 мянган төгрөгөөр өссөн нь Орон нутгийн ерөнхий орлого 819,858.9 мянган

төгрөг болж 567,819.65 мянган төгрөгөөр нэмэгдсэн, ЗДТГ-ын өмч 2,469,378.9 мянган төгрөг болж 798,236.8 мянган төгрөгөөр өссөн тус тус нөлөөлсөн байна.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 912,466.56 мянган төгрөг болж, өмнөх оноос 455,194.32 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	457,272.24	912,466.56	455,194.32
Төгрөг	457,272.24	912,466.56	455,194.32
Төрийн сангийн харилцах	447,939.67	907,923.18	459,983.52
Арилжааны банк дахь харилцах	9,332.57	4,543.37	-4,789.20
<b>Дүн</b>	<b>457,272.24</b>	<b>912,466.56</b>	<b>455,194.32</b>

Эх сурвалж: Баянчандмань Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн Төрийн сангийн харилцах дансны эцсийн үлдэгдэл 907,923.18 мянган төгрөгийн 90,8 хувь буюу 824,608.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогын, 5,8 хувь буюу 52,797.8 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн, 3,4 хувь буюу 30,516.5 мянган төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн дансны үлдэгдэл эзэлж байна. Эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл арилжааны банканд байршиж байна.

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл өмнөх оноос 455,194.32 мянган төгрөгөөр өссөн нь ХХОАТ-н дүн цалин нэмэгдсэнтэй холбоотой 479,919.8 мянган төгрөгөөр давж биелсэнтэй холбоотой байна.

### Аудитын илрүүлэлт

1. Төв аймгийн Баянчандмань сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн Б/01 тоот “Цалин шинэчлэн тогтоох тухай” тушаалаар төрийн албаны улс төрийн албан хаагчийн орон нутгийн нэмэгдэлд 2,525.3 мянган төгрөг олгосон зөрчилд төлбөрийн акт бичив.

2. Орон нутгийн хөгжлийн сангийн мөнгөн гүйлгээний тайлангаар нийт зардал 903.7 мянган төгрөгөөр буруу илэрхийлэгдсэнийг аудитын явцад залруулсан.

3. Орон нутгийн орлогын татварын гүйцэтгэлийг 8 нэр төрлөөр аймгийн Татварын хэлтсийн аудитад ирүүлсэн 2023 оны төсвийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлээс 257,778.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг аудитын явцад залруулсан.

4. Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан нь э тайланд нүүр хуудас байхгүйгээс тус сангийн харилцах дансны 3,534.0 мянган төгрөгийн үлдэгдлийг орон нутгийн орлогын дансанд нэгтгэн тайлагнасан байна.

### 3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 474,889.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 19,924.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	44.4	590.3	546.0
Зээлийн хүүгийн авлага	6,546.3	6,194.3	-352.0
Дансны авлага /ТӨҮГ/	0.0	659.5	659.5
Байгууллагаас авах авлага	32,765.3	31,861.6	-903.7
<b>Хувь хүмүүсээс авах авлага</b>	<b>415,608.6</b>	<b>435,583.6</b>	<b>19,975.1</b>

Эх сурвалж: Баянчандмань Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын жилийн эцсийн үлдэгдэл 474,889.4 мянган төгрөгийн 95,5 хувийг хувь буюу 453,583.6 мянган төгрөгийг хүмүүсээс авах авлага эзэлж байна. Хувь хүмүүсээс авах авлагын 96,7 хувь буюу 421,843.3 мянган төгрөг нь хоршоо, хөгжүүлэх сангийн авлага байна.

### Аудитын илрүүлэлт

Засаг даргын нэгтгэсэн тайлангийн авлагын тодруулга тайланд ОНХС-ийн 1,041.5 мянган төгрөгийн авлага, Хоршоо хөгжүүлэх сангийн 458,497.7 мянган төгрөгийн авлага, Эмийн эргэлтийн сангийн 1,249.8 мянган төгрөгийн авлага, ЗДТГ-ын 14,100.4 мянган төгрөгийн авлага, нийт 474,889.4 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлээгүй гэж тайлагнасныг аудитын явцад залруулсан.

### 3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 190,204.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 299,015.7 мянган төгрөгөөр буурсан байна.

#### Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	479.80	479.80	0.00
Эм боох материал	66,076.20	70,320.23	4,244.03
Бичиг хэргийн материал	961.15	1,229.83	268.68
Аж ахуйн материал	49,544.82	49,775.22	230.40
Барилгын засварын материал	0	770.00	770.00
Бусад хангамжийн материал	36,433.25	36,810.57	377.33
Мал амьтад	5,000.00	5,000.00	0.00
<b>Дүн</b>	<b>158,495.22</b>	<b>164,385.65</b>	<b>5,890.43</b>

Эх сурвалж: Баянчандмань Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын эцсийн үлдэгдэл 164,385.6 мянган төгрөгийн 55,5 хувийг ЗДТГ, 42,8 хувийг эмийн эргэлтийн сан, 1,7 хувийг ИТХ-ын бараа материал эзэлж байна.

Бараа материалын оны эхний үлдэгдэл 5,890.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 234,908.8 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, 229,018.4 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчил байхгүй байна.

### 3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 3,943,079.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 951,638.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

#### Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	807,880.7	807,880.7	0.0
Тээврийн хэрэгсэл	282,079.8	547,969.4	265,889.7
Машин тоног төхөөрөмж	334,333.7	361,648.5	27,314.9
Тавилга эд хогшил	32,589.5	43,559.7	10,970.1
Зам гүүрийн байгууламж	424,123.4	549,703.9	125,580.5
Бусад үндсэн хөрөнгө	975,507.5	1,497,391.0	521,883.6
Программ хангамж	2,040.0	2,040.0	0.0
Бусад биет бус хөрөнгө	132,886.0	132,886.0	0.0
<b>Дүн</b>	<b>2,991,440.5</b>	<b>3,943,079.2</b>	<b>951,638.7</b>

Эх сурвалж: Баянчандмань Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн жилийн эцсийн 3,943,079.2 мянган төгрөгийн үлдэгдлийн 99,4 хувь буюу 3,920,258.6 мянган төгрөгийг сумын ЗДТГ, 0,31 хувь буюу 12,359.1 мянган төгрөгийг ИТХ, 0,27 хувь буюу 10,461.6 мянган төгрөгийг эмийн эргэлтийн сангийн хөрөнгө эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 951,638.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 875,074.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч, төсвийн хөрөнгөөр 222,844.5 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчил байхгүй байна.

### 3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 5,378.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,470.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН</b>	9,848.5	5,378.1	-4,470.4
Ажилчидтай холбогдсон өглөг	4.0	0.0	-4.0
Байгууллагад төлөх өглөг	9,316.8	4,850.4	-4,466.4
Хувь хүмүүст төлөх өглөг	527.7	527.7	0.0

Эх сурвалж: Баянчандмань Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 4,470.4 мянган төгрөгөөр буурсан нь Эмийн эргэлтийн сангийн өглөг буурсантай холбоотой байна.

Өр төлбөрийн жилийн эцсийн 5,378.1 мянган төгрөгийн үлдэгдлийн 4,750.0 мянган төгрөг нь Байгаль орчныг нөхөн сэргээх барьцаа сан, 511,7 мянган төгрөг нь Хоршоо хөгжүүлэх сан, 116.4 мянган төгрөг нь ЗДТГ-ын өглөг эзэлж байна.

Аудитын илрүүлэлт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчил байхгүй байна.

### 3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 3,886,168.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 5,555,283.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Засгийн газрын оруулсан капитал</b>	923,762.0	923,762.0	0.0
Дахин үнэлгээний нөөц	190,358.6	153,653.6	-36,705.0
Хуримтлагдсан дүн	1,491,030.4	2,847,600.9	1,356,570.6
<b>Засгийн газрын хувь оролцооны нийт дүн</b>	2,605,150.9	3,925,016.5	1,319,865.5

Эх сурвалж: Баянчандмань Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 3,925,016.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 1,356,570.6 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төв аймгийн Баянчандмань сумын орон нутгийн төсвийн байгууллагуудын 2023 оны төсвийн төсөлд хүргүүлсэн орлого, зардлыг тооцоолол, төлөвлөгөөг ирүүлээгүй болно.

Баянчандмань сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн “Сумын 2023 оны төсөв батлах тухай” 03 дугаар тогтоолоор 2023 онд төсөвт төвлөрүүлэх татварын ба татварын бус орлогыг 1,108,169.8 мянган төгрөгөөр, төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 1,652,154.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Аудитын илрүүлэлт: Баянчандмань сумын ИТХ-ын 2023 оны 08 сарын 09-ний “Сумын 2023 оны төсвийн тодотгол батлах тухай” 01 дүгээр тогтоолоор сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх шилжих үлдэгдлийн төсөл, арга хэмжээний жагсаалтад ЗДТГ-ын 2023 оны төсөвт бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөрт 40,000.0 төгрөгийг өмгөөлөгчийн хөлсөнд төсөвлөж олгосон зөрчилд албан шаардлага өгөв.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн төслийн саналаас Баянчандмань сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 8 дугаар сарын 09-ний өдрийн 01 дугаар тогтоолд зааснаар Баянчандмань сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 1,325,458.3 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр тодотгон баталж гүйцэтгэлээр 2,038,956.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 153,8 хувиар биелүүлсэн байна.

Тайлант онд орон нутагт төвлөрүүлэх орлого 2,972.1 мянган төгрөгөөр үйл ажиллагааны орлого, 181.8 мянган төгрөгөөр малын тоо толгойн албан татвар, 2,561.4 мянган төгрөгөөр үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, 220.0 мянган төгрөгөөр галт зэвсгийн албан татвар, нийт 5,935.3 мянган төгрөгөөр тасарсан байна.

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар тасарсан нь үл хөдлөх эд хөрөнгийн борлуулалт муу байснаас шалтгаалсан байна.

Төв аймгийн Баянчандмань сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 8 дугаар сарын 09-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор Засаг даргын үйл ажиллагааны зардлыг 657,233.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 2,309,388.5 мянган төгрөгөөр тодотгон, сумын төсөвт аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийн төлөвлөгөөнд 364,169.40 мянган төгрөг, шилжих үлдэгдлийн төлөвлөгөөнд 148,742.5 мянган төгрөгөөр өөрчлөлт оруулсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн 17 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвийн орлогоос 1,325,458.3 мянган төгрөг, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээс 379,974.9 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг 240,000.0 мянган төгрөг, төсвийн урьд оны шилжих үлдэгдлээс 198,742.5 мянган төгрөг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн шилжих үлдэгдэл 165,212.8 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 2,239,011.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 254,795.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,984,216.3 мянган төгрөг буюу 88,6 хувьтай байгаа Хоршоо хөгжүүлэх сангийн зардлыг 131,560.8 мянган төгрөгөөр хэмнэнэс шалтгаалжээ. Нэг жил үйл ажиллагаа явуулсан шалгуур хангасан хоршоо байхгүй байснаас шалтгаалан хоршоо хөгжүүлэх сангийн зардал хэмнэгдсэн байна

Хөрөнгө оруулалтын 6 хөтөлбөрийн 17 арга хэмжээнд 761,390.7 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 631,927.9 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

#### Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Хөтөлбөр	Зарцуулах төсөв	Зарцуулсан	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	70105- Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	87,458.4	79,160.6	8,297.8	90.5%
2	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	945,590.5	908,934.9	36,655.6	96.1%
3	70106-Хоршоо хөгжүүлэх сан	240,000.0	108,439.2	131,560.8	45.2%
4	71802-Ерөнхий боловсролын сургууль-Тогтмол зардал	197,779.6	196,114.5	1,665.1	99.2%
5	71801-Сургуулийн өмнөх боловсрол-Тогтмол зардал	93,061.8	83,696.2	9,365.6	89.9%
6	71702-Соёлын үйлчилгээ-Тогтмол зардал	77,254.0	71,591.4	5,662.6	92.7%
7	71602-Эрүүл мэндийн төв-Тогтмол зардал	35,219.4	35,219.4	0.0	100.0%
8	70106-Орон нутгийн хөгжлийн сан	562,648.2	501,060.1	61,588.1	89.1%
	Дүн	2,239,011.9	1,984,216.3	254,795.6	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар сумын Засаг даргын тамгын газар нь 82,976.9 мянган төгрөг, ИТХ 8,304.6 мянган төгрөг, нийт 91,281.6 мянган төгрөгийг зарцуулсан байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 8 хөтөлбөрийн 19 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 11. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70105- Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	2023.01.01 2023.12.31	Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, тэргүүлэгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээгээр хангах, мэргэшсэн тогтвортой өндөр чадавх бүхий аппарат бүрдүүлж, хуралдааныг зохион байгуулж, шаардлагатай мэдээллээр тасралтгүй хангахад оршино. Жилд 4-өөс доошгүй удаа хурал хийнэ.	90.5%	87,458.4	79,160.6
2	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2023.01.01 2023.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 4 зорилт, хэрэгжүүлэх 8 арга хэмжээ хэрэгжүүлэх	96.1%	945,590.5	908,934.9
3	70106-Хоршоо хөгжүүлэх сан	2023.01.01 2023.12.31	2023 оны 1 сараас Сум хөгжүүлэх санг шинээр Хоршоо хөгжүүлэх сан болгон журмыг дагаж мөрдөх. Хоршоо хөгжүүлэх сангаас иргэн, хоршоонд олгох зээлийг журмын дагуу шаардлага хангасан төсөл шалгаруулан зээл олгох	45.2%	240,000.0	108,439.2
4	71802-Ерөнхий боловсролын сургууль	2023.01.01 2023.12.31	Ерөнхий боловсрол сургууль нь 1 зорилт 3 арга хэмжээ хэрэгжүүлэх	99.2%	197,779.6	196,114.5
5	71801-Сургуулийн өмнөх боловсрол	2023.01.01 2023.12.31	Сургуулийн өмнөх боловсрол нь 1 зорилт 3 арга хэмжээ хэрэгжүүлэх	89.9%	93,061.8	83,696.2
6	71702-Соёлын үйлчилгээ	2023.01.01 2023.12.31	Соёлын төв нь 1 зорилт 3 арга хэмжээ хэрэгжүүлэх	92.7%	77,254.0	71,591.4
7	71602-Эрүүл мэндийн төв	2023.01.01 2023.12.31	Эрүүл мэнд төв нь 2 зорилт 3 арга хэмжээ хэрэгжүүлэх	100.0%	35,219.4	35,219.4
8	70106-Орон нутгийн хөгжлийн сан	2023.01.01 2023.12.31	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр нийт он дамжин хийгдэх 1 төсөл, шинээр хэрэгжих 10 төслийг 395,033.6 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэнэ.	89.1%	562,648.2	501,060.1

Баянчандмань сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 42 бараа, ажил үйлчилгээг худалдан авахаар 1,228,466.9 мянган төгрөгөөр баталсан ба 41 бараа, ажил үйлчилгээг 1,157,478.2 мянган төгрөгөөр худалдан авсан байна.

ИТХ, ЗДТГ, Эрүүл мэндийн төв, Соёлын төвийн 48,934.9 мянган төгрөгийн шатахууны худалдан авалтыг тендер шалгаруулалтын онцгой журмаар 2 удаа зарласан боловч санал ирүүлсэн оролцогч байхгүй байсан тул НИК ХК-аас шууд худалдан авалт хийсэн байна.

ЕБС, СӨБ, ЭМТ-ийн 73,746.2 мянган төгрөгийн хоол хүнс, үдийн цайны материал нийлүүлэх 2 багц худалдан авалтыг тендер шалгаруулалтын онцгой журмаар 2 удаа зарласан боловч санал ирүүлсэн оролцогч байхгүй байсан тул Элбэг сэлэс ХХК-аас шууд худалдан авалт хийсэн байна.

ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 11 төсөл арга хэмжээг худалдан авахаар төлөвлөсөн байна. Үүнээс 5 төсөл арга хэмжээг 195,033.6 мянган төгрөгөөр гүйцэтгүүлэхээр худалдан авалтыг тендер шалгаруулалтын онцгой журмаар, зарласан байна. Цэцэрлэгийн гадна талбайн тохижилтын ажлыг Азиякомплект ХХК, сумын гэр хороолол гудамжны сайжруулсан зам засварын ажлыг Чандмань Төгөлдөр Гэрэгэ ХХК, 3-р хорооны хүүхдийн тоглоомын талбайг засварлах, шинэчлэх ажлыг Азиякомплект ХХК, 3-р хорооны гүүрийг бүрэн засварлах ажлыг Чандмань Төгөлдөр Гэрэгэ ХХК хийж гүйцэтгэхээр тус тус шалгаран хийж гүйцэтгэсэн байна.

Ковш, гал командын тоноглогдсон автомашины 257,560.0 мянган төгрөгийн худалдан авалтыг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зарласан ба тендерт шалгарсан Ай ВАЙ И Зэт ХХК, Хазаарбат ХХК-аас тус тус барааг хүлээн авсан байна. Сургуулийн гадна биеийн тамирын талбайг тохижуулах, Чандмань багын гэрэлтүүлгийн засвар шинэчлэл, Замт багын гэрэлтүүлгийн засвар шинэчлэл, Эрдэнэ багын гэрэлтүүлгийн засвар шинэчлэлийг нийт 60,000.0 төгрөгөөр шууд гэрээ байгуулан Азиякомплект ХХК, Нуклон ХХК-аар хийж гүйцэтгүүлсэн байна. Хуц ухны өвөлжөө барих 24,468.7 мянган төгрөгийн ажлыг тендер шалгаруулалтын онцгой журмаар 2 удаа зарласан бөгөөд санал ирүүлсэн оролцогч байхгүй байсан тул худалдан авалтыг

Орон нутгийн төсвөөс сумын ариутгах татуургын төв шугамын угсралтын ажлыг тендер шалгаруулалтын онцгой журмаар зарлан Мөнх зүмбэр ХХК 99,990.9 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэсэн байна. Соёлын төвийн акустикийн 30,000.0 төгрөгийн худалдан авалтыг тендер шалгаруулалтын онцгой журмаар зарласан ба Эм Си Ар Эл ХХК шалгаран 24,997.5 мянган төгрөгөөр нийлүүлсэн байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын орлого бүрдүүлэлт, шилэн дансны мэдээллийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Адъяасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт сумын Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 01/21 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сумын 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаас нийт орлого, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаас нийт орлого 1,969,029.1 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 29,535.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 22,151.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Баянчандмань сумын төсөвт 5 байгууллага нийт 64,922.5 мянган төгрөгийн зардал хэмнэн ажилласан байна.

Засаг даргын Тамгын газар нь Үндсэн үйл ажиллагааны зардлаас бүтэц орон дутуугаас цалинг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 4,356.4 мянган төгрөг, тээвэр шатахууны зардлаас 72.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 9,276.8 мянган төгрөг, хөрөнгийн зардлаас 6,653.6 мянган төгрөгийн зардлыг тус тус хэмнэсэн байна. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 13,431.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 6,140.7 мянган төгрөг, нийт 39,931.6 мянган төгрөгийн зардал хэмнэн ажилласан байна.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үндсэн үйл ажиллагааны цалин, урамшуулал нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 7,971.2 мянган төгрөг, шуудан холбоо, бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 326.4 мянган төгрөг, нийт 8,297.6 мянган төгрөгийн зардал хэмнэн ажилласан байна.

Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Соёлын төв нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 16,693.1 мянган төгрөгийн зардлын хэрэглээгээ багасган хэмнэн ажилласан байна.

ОНХС-аас дараа он руу шилжсэн 1 арга хэмжээний зардал Хуц ухнын өвөлжөө барих ажил 24,468.7 мянган төгрөг, тендер зарлахтай холбоотой хэмнэгдсэн зардал 37,119.3 мянган төгрөг, нийт 61,588.0 мянган төгрөг хэмнэн ажилласан байна.

ХХС-аас зээлийн шалгуур үзүүлэлт хангасан хоршоо байхгүйгээс шалтгаалан 131,560.7 мянган төгрөгийн зардал хэмнэгдсэн байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 178 мэдээлэл байршуулахаас 153 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 25 мэдээлэл хугацаа хоцроож, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 607,060.1 мянган төгрөгийн 25 мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 422,943.7 мянган төгрөгийн 15 мэдээлэл, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэлтэй холбоотой 17,664,890.6 мянган төгрөгийн 52 мэдээлэл, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэлтэй холбоотой 42 мэдээлэл хугацаанд нь байршуулсан байна.

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

*Аудитын илрүүлэлт: Баянчандмань сумын Хоршоо хөгжүүлэх сан Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 5,321.4 мянган төгрөгийн 1 гүйлгээ, Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 106,000.0 мянган төгрөгийн 6 гүйлгээ, Төсөв хөрөнгө зарцуулах тухай 7 ширхэг шийдвэрийг шилэн дансны цахим системд мэдээлээгүй байсныг аудитын явцад нөхөн мэдээлсэн.*

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийж, аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн төлбөрийн акт, албан шаардлага зөвлөмжийг хэрэгжүүлэн, сумын Засаг даргын 2023 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн 01/216 дугаартай албан бичгээр хэрэгжилтийг ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	2	37,535.3	2	37,535.3	100
Нийт дүн	2	37,535.3	2	37,535.3	100

/мянган төгрөгөөр/

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баянчандмань сумын ОНХС-ийн иргэдийн санал авсан байдал, тендер шалгаруулалт, зарцуулалттай холбоотой асуудлыг авч үзэх.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

### Залруулсан алдаа

Аудитаар нийт 732,667.5 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 732,667.5 мянган төгрөгийн алдааг залруулав.

1. Засаг даргын нэгтгэсэн үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд Төрийн сангийн харилцах дансны татварын орлогын гүйцэтгэлийг 8 нэр төрлөөр аймгийн Татварын хэлтсийн аудитад ирүүлсэн 2023 оны төсвийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлээс 257,778.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

2. Засаг даргын нэгтгэсэн тайлангийн авлагын тодруулга тайланд 474,889.4 мянган төгрөгийн авлагын насжилтыг оруулаагүй, тооцоо нийлээгүй гэж тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "ангилал", "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 5,945.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 5,945.4 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлсэн.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлого бүрдүүлэлтэй холбоотой асуудал

#### Илрүүлэлт:

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 153,8 хувиар давж биелсэн боловч 4 нэр төрлийн орлого 1.0-13.5 хувиар буюу 5,935.3 мянган төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу

хэрэгжүүлнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр жигд биелүүлэх

**2. Орлого бүрдүүлэлтэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:**

Орлогын гүйцэтгэлийн тодруулга тайланд төсвийн орлогын гүйцэтгэлийг 2,038,956.7 мянган төгрөгөөр, аймгийн Татварын хэлтсийн аудитад ирүүлсэн 2023 оны төсвийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлээс 10.1 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:**

Татварын байцаагчтай орлогын дүнг сар улирлаар тохирч байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
<b>A</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>	<b>7</b>	<b>8</b>	<b>9</b>	<b>10</b>
1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1		1					
2	Засаг даргын тамгын газар	1	1				1		
3	Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан	1		1					
4	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
5	Эмийн эргэлтийн сан	1		1					
6	Орон нутгийн хөгжлийн сан	1		1					
	<b>НИЙТ</b>	<b>6</b>	<b>1</b>	<b>5</b>			<b>1</b>		

